



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 348

Улаанбаатар хот

“Зуун дэлгэрэх” ХХК-д банк бус санхүүгийн  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.3, 22.1, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 10.1.1, 15.3.1, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Зуун дэлгэрэх” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Зуун дэлгэрэх” ББСБ ХХК /Ч.Алтанчимэг/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавин олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

